

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

Оршил	4-5
Бүлэг 1. Төслийн товч танилцуулга	6
1.1 Тайлангийн нэр	6
1.2 2024 оны төлөвлөлтийн нийт бүтээгдэхүүний хэмжээ	6
1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга.....	6
1.4 Төслийн байршил.....	7
1.5 Орд ашиглах тусгай зөвшөөрөл	8
1.6 Ашиглалтын системийн сонголт	8
1.7 Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, ашиглалтын нөөц	9
1.8 Төсийн хүчин чадал	9
1.9 Ил уурхайн ажлын горим	9
Бүлэг 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл	10
2.1 Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт.....	10-15
2.2 Нөхөн сэргээлтийн биелэлт	16-20
2.3 Тэр бум мод төслийн хүрээнд.....	21-22
2.4 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	23-25
2.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олгооор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	25
2.6 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	26
2.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	26-29
2.8 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	29
2.8.1 Энгийн хог хаягдал	29
2.8.2 Аюултай хог хаягдал	30-32
2.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд	32-33
2.10 Ус ашиглалтын гэрээний хэрэгжилт, гүйцэтгэл	34
2.10.1 Усны эх үүсвэрийн хамгаалалтын талаар	35
2.10.2 Усан орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	34-35
2.10.3 Ус ашигласны дүгнэлт	35
2.10.4 Хаягдал усны дүгнэлт	35

2.11 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт .37	
2.12 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт38-40	
Дүгнэлт	41
Ашигласан материал	42
Хавсралтын жагсаалт	43

ХҮСНЭГТИЙН ХАВСРАЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	6
Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн эргэлтийн цэгүүдийн солбилцол.....	7
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэл .10	
Хүснэгт 4. Мод тарьж ургуулах.....	21
Хүснэгт 5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэл.....	23
Хүснэгт 6. Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох талаар	25
Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл	26
Хүснэгт 8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл	29
Хүснэгт 9. Хуримтлуулсан аюултай хог хаягдал	31
Хүснэгт 10. ОХШХ-ийн гүйцэтгэл	33
Хүснэгт.11 БОМТ-ний хэрэгжилтэд зарцуулсан зардал	37
Хүснэгт 12. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөөний гүйцэтгэл	38
Хүснэгт 13. Орон нутгийн хамтын ажиллагааны хүрээнд	39
Хүснэгт 14 2024 оны нийт зардал	42

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байр зүйн зураг.....	8
Зураг 2. Уурхайн суурьшлын бүсэд хайрган хучилт хийсэн байдал.....	13
Зураг 3. Уурхайн суурьшлын бүсэд угаалгын газар хийсэн байдал.....	13
Зураг 4. Уурхайн суурьшлын бүсэд тохижилт хийсэн байдал.....	14
Зураг 5. Уурхайн дотоод замд нэг маршрут гаргасан байдал.....	14
Зураг 6. Уурхайн тэмдэг, тэмдэглэгээний зураг.....	15
Зураг 7. Тоосжилт үүсэхээс сэргийлж замын усалгааг хийсэн байдал.....	15
Зураг 8. Ус зөөвөрлөж байгаа байдал.....	16

Зураг 9.	Хүнд машин механизмуудын засвар үйлчилгээ.....	16
Зураг 10.	Нөхөн сэргээлт хийгдээгүй талбай	17
Зураг 11.	Шимт хөрс гаргаж байгаа байдал.....	17
Зураг 12.	Шимт хөрсний овоолго.....	18
Зураг 13.	Шимт хөрсийг тарааж хөрсжүүлж байгаа байдал.....	18
Зураг 14.	Шимт хөрсөнд олон наст үр тарьж байгаа байдал.....	19
Зураг 15.	Шимт хөрсөнд олон наст үр ургасан байдал.....	20
Зураг 16.	Гэрээ болон төлбөр төлсөн баримт	22
Зураг 17.	Мод тариалж буй байдал	22
Зураг 18.	Улаан дэлийг нөхөн сэргээсэн байдал	24
Зураг 19.	Өртөнтийг нөхөн сэргээхээс өмнөх байдал.....	24
Зураг 20.	Нөхөн сэргээлт хийсний дараах байдал.....	24
Зураг 21.	Нөхөн сэргээж буй үйл явц	25
Зураг 22.	Уурхайн гэрэлтүүлэг сайжруулсан байдал	27
Зураг 23.	Галын багажны сараа, галын аюулгүй байдлын дүгнэлтүүд	27
Зураг 24.	Галын аюулгүй байдлын самбар, тэмдэгүүд байршуулсан байдал	28
Зураг 25.	Далан хаягдлын сан байгуулсан байдал	28
Зураг 26.	Энгийн хог, хаягдлыг цуглуулах цэг	29
Зураг 27.	Гэрээ, төлбөр төлсөн баримт	30
Зураг 28.	Аюултай хог хаягдлын зөвшөөрөлтэй ААН-н мэдээлэл.....	30
Зураг 29.	Бүртгэлийн хуудас бөглөсөн байдал	31
Зураг 30.	Аюултай хог хаягдлыг цуглуулсан байдал	31
Зураг 31.	Аюултай хог хаягдлын тайлангийн маягт	31
Зураг 32.	Шинжилгээний дүгнэлтүүд	33
Зураг 33.	Ажлын тайланг харуулсан байдал	34
Зураг 34.	Ус ашигласны дүгнэлт	35
Зураг 35.	Хаягдал усны дүгнэлт	36
Зураг 36.	Хаягдал усны төлбөрийн баримт	37
Зураг 37.	Ажилчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулсан байдал	38
Зураг 38.	Ажилчдыг хөдөлмөр хамгааллийн хувцас, хэрэгслээр хангасан байдал	38
Зураг 39.	Зам даваа засаж, янзлах үеийн байдал.....	39
Зураг 40.	Өрхөд өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд тусламж үзүүлсэн баримт	40

ОРШИЛ

Энэхүү Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан нь:

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан гол болон сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт, тэрбум мод төслийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын биелэлт, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлт, нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, осол, эсрдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт, хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт зэргээс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь: Албан ёсны баримт бичиг бөгөөд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд жил бүрийн байгаль орчны биелэлтийг хянан үзэж, батлуулж байх шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн гол зорилго нь: “Эм эс бэл майнинг” ХХК-ий уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэсэн байх шаардлагатай ажлыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд тайлагнахад оршино.

“Өртөнт”-ийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон орд нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймгийн Байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт нь: 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу төслийн үйл ажиллагааны бүхий л үе шат бүрт байгаль орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын дагуу төсөл хэрэгжүүлэгч “Эм эс бэл майнинг” ХХК-ий авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн дагуу боловсруулав.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийж боловсруулж, холбогдох материалуудыг хавсаргалаа.

“Өртөнт”-ийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2024 онд нийт 17.152.000 /арван долоон сая нэг зуун тавин хоёр мянган/ төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Тайлангийн нэр

Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт орших 40.64 га талбайг хамарсан MV-000436 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаартай, “Өртөнт”-ийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ашиглах төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.

1.2 2024 оны төлөвлөлтийн нийт бүтээгдэхүүний хэмжээ

2024 онд Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах “Өртөнт”-ийн В, С блокод уулын ажлыг явуулахаар төлөвлөсөн.

Үүнээс 105.43 мян.м³ элс олборлож, 60.2 мян.м³ хөрс хуулагдах ба 9.46 кг металл олборлож борлуулахаар ажилласан.

1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд	
1	Аж хайун нэгжийн нэр	“Эм эс бэл майнинг” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар	9011839169
3	Уурхайн нэр	Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон орд
4	Ордны нэр	Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон орд
5	Ордны байршил	Аймаг Өвөрхангай
6		Сум Зүүнбаян-Улаан
7	Ашигт малтмалын төрөл	Алтны үүсмэл болон шороон
8	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	МУ-000436
9	Ашиглаж эхэлсэн огноо	
10	Компаний хаяг	Аймаг Өвөрхангай
11		Сум Арвайхээр
12		Баг 8 дугаар баг
13		Гудамж/байр/ 339 дүгээр байр 39 тоот
14		Гар утас 89298252
15		Цахим шуудан Toogit827@gmail.com
16		Цахим хуудас
17	Захиралын хаяг	Нэр Б.Тогооч
18		Гар утас 89298252
19		Цахим шуудан Toogit827@gmail.com


Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших “Өртөнт”-ийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл шороон ордыг ашиглах төслийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

1.4 Төслийн байршил

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн эргэлтийн цэгүүдийн солбилцол

№	Уртраг			Өргөрөг		
	Град	Мин	Сек	Град	Мин	Сек
1	102	23	15.23	46	37	39.36
2	102	23	18.88	46	37	39.44
3	102	23	18.28	46	37	52.23
4	102	23	25.56	46	37	52.39
5	102	23	25.24	46	37	58.86
6	102	23	26.17	46	37	58.87
7	102	23	25.4	46	37	14.92
8	102	23	23.9	46	37	14.03
9	102	23	21.09	46	37	6.93
10	102	23	21.17	46	37	5.24
11	102	23	20.42	46	37	5.23
12	102	23	18.16	46	37	59.51
13	102	23	18.2	46	37	58.7
14	102	23	17.83	46	37	58.68
15	102	23	3.48	46	37	22.43
16	102	23	3.76	46	37	16.85
17	102	23	3.97	46	37	16.81
18	102	23	4.21	46	37	16.76
19	102	23	4.33	46	37	16.74
20	102	23	4.91	46	37	16.6
21	102	23	5.08	46	37	16.56
22	102	23	5.28	46	37	16.5
23	102	23	5.68	46	37	16.38
24	102	23	6.23	46	37	16.2
25	102	23	6.3	46	37	16.17
26	102	23	6.48	46	37	16.1
27	102	23	6.94	46	37	15.92
28	102	23	7.45	46	37	15.68
29	102	23	7.59	46	37	15.62
30	102	23	7.74	46	37	15.54
31	102	23	8.1	46	37	15.35
32	102	23	8.56	46	37	15.07
33	102	23	8.78	46	37	14.92
34	102	23	8.87	46	37	14.85
35	102	23	9.09	46	37	14.7
36	102	23	9.5	46	37	14.38
37	102	23	9.66	46	37	14.24
38	102	23	9.75	46	37	14.16
39	102	23	9.96	46	37	13.97
40	102	23	10.31	46	37	13.61
41	102	23	10.33	46	37	13.58
42	102	23	10.42	46	37	13.48
43	102	23	10.67	46	37	13.19
44	102	23	32.12	46	37	13.68
45	102	23	31.8	46	37	20.15
46	102	23	27.11	46	37	20.04
47	102	23	26.96	46	37	23.28
48	102	23	23.43	46	37	23.2
49	102	23	23.03	46	37	26.45
50	102	23	16.08	46	37	26.42

Зураг 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байр зүйн зураг



1.5 Орд ашиглах тусгай зөвшөөрөл

Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын 1 дүгээр багийн нутаг дэсгэрт орших “Өртөнт” нэртэй 40.64 га талбай бүхий ашигт малтмалын MV-000436 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Гурван тамга” ХХК-д 30 жилийн хугацаатай олгосон байна.

Улмаар 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 174 дугаар тушаалаар “Ирмүүн босго” ХХК-аас “Цариг шонхор” ХХК-д шилжүүлсэн байна. 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 95 дугаар тушаалаар “Цариг шонхор” ХХК-аас “Эм эс бэл майнинг” ХХК-нд шилжүүлсэн байна.

1.6 Ашиглалтын системийн сонголт

Ордыг ил аргаар ашиглана.

1.7 Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, ашиглалтын нөөц

Өртөнтийн үүсмэл ордын хэсгийн С-3, С-2 блокууд урд болон хажуу талаараа тусгай зөвшөөрлийн хилд тулсан байгаа нь уурхайн хажуу хананд батлагдсан нөөцөөс зайлшгүй хаягдал үүсэх нөхцлийг бүрдүүлж байна. Уурхайн эцсийн хүрээ хязгаарыг тодорхойлон ашиглалтын нөөцийг тооцоход нийт нөөцөөс 3.16 мян.м³ элс /0.33 кг металл хими цэвэр/ ил уурхайн хүрээ хязгаарын гадна хаягдан уурхайн хүрээ хязгаарт В+С зэрэглэлээр 119.69 мян. М³ элс /12.37 кг алт хими цэвэр/ ил уурхайн хүрээ хязгаараар хязгаарлагдан хаягдана.

1.8 Төслийн хүчин чадал

Ил уурхайн жил бүрийн олборлолт харилцан адилгүй байх ба төслийн жилд 105.3 мян.м³ элс олборлоно.

Ил уурхайн олборлолтыг төлөвлөсөн хүчин чадлаар тооцоход Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордын нөөцийг 2 жилийн хугацаанд олборлоно.

1.9 Уурхайн ажлын горим

Уурхайн олборлолт хөрс хуулалтын үйл ажиллагаа нь тухайн жилийн 2 дугаар улирлаас 3 дугаар улирлын хооронд дулааны улиралд явагдах бөгөөд техникийн даалгаврын дагуу 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Угаан баяжуулах хэсэг нь 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Ашиглалтын технологи: “Өртөнт”-ийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордын хөрсний зузаан нь таазны бохирдол хасаж тооцсоноор дундаж 2м байна. Иймд шимт хөрсийг 0.2м зузаантайгаар хуулан овоолно.

Ордын элс хэвтээ ойролцоогоор 30 уналттай, нөөцийн блокуудын өргөн жигд үргэлжилдэг тул ашиглалт явуулсан талбайд дотоод овоолго хийж ашиглах ба ордын ашиглалтад ил аргаар авто тээвэртэй гадаад дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглана.

Шимт хөрс хуулалт: Шимт хөрсийг CAT D-8 маркийн бульдозероор түрж шимт хөрсний овоолгод овоолно. Шимт хөрсний овоолгыг 350 градусын налуутайгаар үерийн ус болон салхины нөлөө бага байх газар байгуулна. Шимт хөрсийг уурхайн талбайгаас 0.2м зузаантайгаар 9.94 мян.м³ /сийрэгжээгүйгээр/ шимт хөрс хуулж овоолно.

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэлийн хүснэгт

№	Хэрэгжүүлсэн ажил	2024 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
Агаарын чанар			
1	Уурхайн дотоод тээвэрлэлтийн авто замуудад усалгаа хийх, ялангуяа хуурайшилтай хаврын улиралд тогтмол усалж байх, олон салаа зам гаргахгүй байх үүднээс замын тэмдэглэгээг хийх, үйл ажиллагаандаа мөрдөх	Үйл ажиллагааны зардлаар	Уурхайн хотхоныг тойруулан чулуугаар гортиг татаж, зогсоол болон хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглэгээ хийж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан. Угаан баяжуулах төхөөрөмжийн гааль, шламын тээвэрлэлтийг уурхайн дотоод замд ашиглан тоосжилтийг дарах арга хэмжээ авч ажилласан ба мөн хайрган хучилт хийж байсан. Тоосжилтоос сэргийлэн өөрийн дотоод нөөц боломжийг ашиглан зөөврийн усалгааны аргыг ашиглан тогтмол усаар шүршиж, усалж ажилласан.
2	Уурхайн агаарын шинжилгээг улиралд нэг удаа зайлшгүй мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж байх шаардлагатай	ОХШХ-ийн биелэлтэд тусгагдсан	Агаарын шинжилгээг Өвөрхангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор 2024 оны 07, 09 дүгээр саруудад 2 удаа хийлгэж ажилласан байна.
3	Тээврийн хэрэгсэл хүнд даацын машины хурдыг тогтмолжуулах, машин техникийн үзлэг шалгалтыг төлөвлөгөөт хугацааны дагуу тогтмолжуулж, байгаль орчинд сөрөг нөлөөтэй, утаа, хорт хий ихээр ялгаруулах техникийн шаардлага хангахгүй техник, технологийг шинэчилж, аюулгүй ажиллагааг хангах	32100.5	Замын хөдөлгөөний дүрмийн хичээлээр ХАБЭА хариуцсан ажилтан, хууль зүйн ухааны магистр Н.Өлзийхутаг 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр сургалт орж, 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тестээр шалгалт авч ажилласан байна. Ингэснээр ажилтан бүрийн замын хөдөлгөөний дүрмийн мэдэглэг сайжирч, аюулгүй үйл ажиллагааг ханган ажиллах болсон. Мөн тээврийн хэрэгсэл хүнд даацын машины хурдыг тогтмолжуулж, машин техникийн үзлэг шалгалтыг төлөвлөгөөт хугацааны дагуу хамруулж ажилласан. Өдөр бүр ээлж хүлээлцэхээс 30 минутын өмнө зогсолт хийж машин техникэд шаардлагатай тосолгоо, үйлчилгээг хийж хэвшээд байна. Байгаль орчинд сөрөг нөлөөтэй, утаа, хорт хий ихээр ялгаруулах техникийн шаардлага хангахгүй тээврийн хэрэгслийг шинэчилж,

Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших “Өртөнт”-ийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл шороон ордыг ашиглах төслийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

			аюулгүй ажиллагааг ханган ажилласан.
Хөрсөн бүрхэвч			
1	Олборлолт дууссаны дараа байгаль орчны унаган төрхийг хэвээр хадгалж үлдэхийн тулд нөхөн сэргээлтийн ажлыг чанартай гүйцэтгэж орон нутагт хүлээлгэн өгч байх	Үйл ажиллагааны зардлаар	Олборлолт дууссаны дараа байгаль орчны унаган төрхийг хадгалж үлдэхийн тулд нөхөн сэргээлтийг чанартай гүйцэтгэн ажиллаж байна. <u>Тухайлбал:</u> 2023 онд уг газарт урд нь бичил уурхайн үйл ажиллагааны улмаас болон гар аргаар ашигт малтмал олборлогчдын ухсан газар, өөрсдийн олборлосон газраас 10.03 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж холбогдох газруудад хүлээлгэн өгсөн. 2024 онд Уулын ажлын төлөвлөгөө болон БОМТ-ний дагуу 2.5 га талбайд биологийн, 2.5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээр тусгасан ч бичил уурхайн үйл ажиллагааны улмаас болон гар аргаар ашигт малтмал олборлогчдын ухсан газар, мөн өөрсдийн олборлосон газраас 5 га газарт техникийн нөхөн сэргээлт хийж, 2.5 га газар нь олон наст зүлэг тарьж биологийн нөхөн сэргээлт хийж ажилласан байна.
2	Уурхайн хөрсний шинжилгээг улиралд нэг удаа зайлшгүй мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж байх шаардлагатай	ОХШХ-ийн биелэлтэд тусгагдсан	Хөрсний шинжилгээг Өвөрхангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор 2024 оны 07, 09 дүгээр саруудад 2 удаа хийлгэж ажилласан байна.
3	Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явуулахгүй байх, хориглосон таних тэмдэгүүдийг сайжруулах, нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны зардлаар	Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар зорчуулахгүй байх арга хэмжээг авч, аймгийн “Олонлог” хэвлэлийн компаниар замын тэмдэг, тэмдэглэгээнүүдийг гэрэл ойлгогчтойгоор хэвлүүлэн замын тэмдэг, тэмдэглэгээнүүдийг байршуулан ажилласан.
4	Өнгөн хөрсийг хуулан авах, уурхайн үйл ажиллагааг эхлэхээс өмнө болон ажлын явцад хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах	Үйл ажиллагааны зардлаар	Уулын ажлын ахилтанд өртөж буй зам, талбайн шимт хөрсийг стандартын дагуу хуулан Уурхайн биологийн нөхөн сэргээлтийн ажилд ашиглах зорилгоор нийт 7 хэсэг шимт хөрсний овоолго үүсгэн техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд бууцтай холин хөрсжүүлэн ажилласан байна.
5	Шимт хөрсний овоолгыг салхинд хийсэх, усанд автах бохирдохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх		Шимт хөрсний овоолгыг салхинд хийсэх, усанд автах, бохирдохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэн ажилласан. Шимт

Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших “Өртөнт”-ийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл шороон ордыг ашиглах төслийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

			хөрсийг удаан хугацаанд хадгалах шаардлагагүй байсан тул тусгайлан зассан талбайд овоолго үүсгэн, бууцтай холиод хөрсжүүлэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.
Усан орчин			
1	Унд, ахуйн ус болон усалгааны усны дээж авч лабораториор шинжлүүлэх	ОХШХ-ийн биелэлтэд тусгагдсан	Унд, ахуйн ус болон усалгааны ус, цэвэр, бохирын нуурын усны шинжилгээг Өвөрхангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор 2024 оны 07, 09 дүгээр саруудад 2 удаа хийлгэж ажилласан байна.
2	Худгийг тоолууржуулах усны зарцуулалтыг тоолуурын заалтад үндэслэн хянаж байх, тооцоолсон усны хэрэглээг хэтрүүлэхгүй байх	Хаягдал усны төлбөр 4534.583,36	Усны газарт хаягдал усны болон ундны ус бусад холбогдох материалыг хүргүүлэн хаягдал усны төлбөр 4.534.583.36 /дөрвөн сая таван зуун гучин дөрвөн мянга таван зуун наян гурван/ төгрөг гарсныг Татварын газарт бүргүүлэн төлбөрийг төлж ажилласан. Мөн худаг байхгүй, Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын 1 дүгээр баг баруун гол буюу Өртөнтийн голоос ундны усаа авдаг. Ус ашиглах гэрээг байгуулан, гэрээний дагуу 4.534.583.36 /дөрвөн сая таван зуун гучин дөрвөн мянга таван зуун наян гурван/ төгрөгийн төлбөрийг төлж ажилласан. Тооцоолсон усны хэрэглээг хэтрүүлээгүй болно.
3	Шатах, тослох материал хөрсөнд асгарахаас сэргийлэх, асгарсан тохиолдолд тухай бүр саармагжуулах арга хэмжээ авах	Үйл ажиллагааны зардлаар	Шатахуун хадгалах саванд галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулан, түлшийг тогтоосон цэгээс хангаж байгаа бөгөөд шаадлагатай тохиолдолд 3 тонны шатахуун тээвэрлэх запрушикар /мөн галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулсан/ зөөвөрлөн олгож байна. Хаягдал тос, маслыг цементээр тусгаарласан, хаягдал тос, масло гэсэн самбар бүхий тусгай талбайд бүтүү саванд хадгалж байна. Мөн түлш түгээх цэгт үүссэн бохирдолыг тэр даруй цэвэрлэх, нэмж хайрган хучилт хийх зэрэг арга хэмжээ авч ажилласан.
Амьтан			
1	Уурхайн талбайд мал, амьтан унаж гэмтэхээс сэргийлэх зорилгоор хашаа хамгаалалт хийх	Үйл ажиллагааны зардлаар	Далан, хаягдлын сангийн тодорхой байршлыг ойр орчмын мал бүхий иргэдэд мэдээлж, далан хаягдлын сангийнхаа аюулгүй байдлыг ханган тэмдэг, тэмдэглэгээг байршуулан,

Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших “Өртөнт”-ийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл шороон ордыг ашиглах төслийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан


			хүн, малын осол эндэгдлээс сэргийлэх арга хэмжээ авч ажилласан.
2	Хууль бус агнуур хийхгүй байхад анхаарч хяналт тавих	Үйл ажиллагааны зардлаар	Хууль бус агнуур хийхгүй байхад анхаарч, хяналт тавьж ажилласан бөгөөд уурхайн орчимд үйл ажиллагаа эхэлснээс хойш хулайн анчид байхгүй болсон. Харин ч эсэргээрээ тарваганы тоо толгой өссөн эерэг байдал үүссэн.
3	Хаягдал усан санруу шувуу унах, хаягдал усан сангаас ундаалахаас сэргийлж шувуу үргээгч байрлуулах	Үйл ажиллагааны зардлаар	Хаягдал усан санруу шувуу унах, хаягдал усан сангаас ундаалахаас сэргийлж шувуу үргээгч байрлуулсан.

Уурхайн суурьшлын бүсийг тойруулан чулуугаар гортиг татсан бөгөөд суурьшлын бүсэд хайрган хучилт хийж ажилласан.

Зураг 2. Уурхайн суурьшлын бүсэд хайрган хучилт хийсэн байдал



Зураг 3. Уурхайн суурьшлын бүсэд угаалгын газар хийсэн байдал



Зураг 4. Уурхайн суурьшлын бүсэд тохижилт хийсэн байдал



Уурхайн орчимд тоосжилтийг багасгах, замын хөдөлгөөний дүрмийг мөрдөх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүднээс тусгай техникээр нэгдсэн зам гаргаж түүгээрээ тээвэрлэлт хийэ ажиллаж байна.

Мөн угаан баяжуулах төхөөрөмжийн гааль, шламын тээвэрлэлтийг уурхайн дотоод замд ашиглан тоосжилтийг дарах арга хэмжээ тогтмол авч хэрэгжүүлсэн.

Зураг 5. Уурхайн дотоод замд нэг маршрут гаргасан байдал



Тоосжилт үүсэж болзошгүй, уурхайн бүсэд гадны машин, техник, хүн нэвтрэн орж болзошгүй, аваар осол гарч болзошгүй газруудад, мөн тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар зорчуулахгүй байх арга хэмжээг авч, аймгийн “Олонлог” хэвлэлийн компаниар замын тэмдэг, тэмдэглэгээнүүдийг гэрэл ойлгогчтойгоор хэвлүүлэн мэдээлэх болон хориглох, анхааруулах, зүг чиг заасан тэмдэг, тэмдэглэгээнүүдийг байршуулан ажилласан.

Зураг 6. Уурхайн тэмдэг, тэмдэглэгээний зураг



Зураг 7. Тоосжилт үүсэхээс сэргийлж замын усалгааг хийсэн байдал




Усны шинжилгээг Өвөрхангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор 2024 оны 07, 09 дүгээр саруудад 2 удаа хийлгэж сорилын дүнг авч ажилласан байна. Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын 1 дүгээр баг баруун гол буюу Өртөнтийн голоос ундны усаа авдаг. Ус ашиглах гэрээг байгуулан, гэрээний дагуу төлбөрийг төлж ажилласан. Тооцоолсон усны хэрэглээг хэтрүүлээгүй болно.

Зураг 8. Ус зөөвөрлөж байгаа байдал



Зураг 9. Хүнд машин механизмуудын засвар үйлчилгээ



2.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

“Өртөнт”-ийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл шороон ордод өмнөх жилүүдэд буюу 1996 оноос бичил уурхайн үйл ажиллагааны улмаас болон гар аргаар ашигт малтмал олборлогчдын ухаж сүйтгэсэн 8,78 га талбай эвдрэлд өртсөн байсан. Үүнээс 2023 онд 2.82 га, 2024 онд 2.5 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 2.5 га-д биологийн нөхөн сэргээлт хийж ажилласан. Ашиглалтын жилүүдэд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийгээд ашиглалт дууссаны дараа 3 дахь жилд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийхээр төлөвлөөд байна.

“Эм эс бэл майнинг” ХХК нь байгаль орчны сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, нөхөн сэргээх зэрэг замаар учирч болох сөрөг нөлөөллийг хамгийн бага хэмжээнд барьж байгаль орчны хувьд тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

Манай компани нь Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын 1 дүгээр баг Өртөнт гэх газар жалгын эхэнд урдны ажиллаж байсан уул, уурхайн компаниудын болон гар аргаар алт олборлох үйл ажиллагаа явуулж байсан иргэдийн 1996 оноос хойш нөхөн сэргээлт хийгдээгүй 2.5 га талбайд, мөн 2024 онд ашиглах блок бүхий 2.5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж, технологийн дагуу хөрсжүүлэн олон наст зүлэг тарьж, зүлэгжүүлэн ажилласан.

“Эм эс бэл майнинг” ХХК нь 2024 онд Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын 1 дүгээр баг Өртөнт гэх газарт 5 га талбайд 20.000.000 /хорин сая/ төгрөгийн зардлаар техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн байна.

Зураг 10. Нөхөн сэргээлт хийгдээгүй талбай



Зураг 11. Шимт хөрс гаргаж байгаа байдал



Зураг 12. Шимт хөрсний овоолго



Зураг 13. Шимт хөрсийг тарааж хөрсжүүлж байгаа байдал



Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших “Өртөнт”-ийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл шороон ордыг ашиглах төслийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан



Зураг 14. Шимт хөрсөнд олон наст үр тарьж байгаа байдал



Зураг 15. Шимт хөрсөнд олон наст үр үргэсэн байдал



Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших “Өртөнт”-ийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл шороон ордыг ашиглах төслийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

5/23/24, 9:02 AM mail-attachment.googleusercontent.com/attachment/?ui=2&ik=3610a6b8&ikid=0.1&emmgid=msg.4179976428402079310...


Бүртгэгдсэн Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт

ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ДТД: 9900074948000407200000185311 Огноо: 2024-05-22
 Баруун нэвчлэл: Хувиараа ажлаа: ГТД: 6862579
 ГТД: 9429489 ХТД: 6862579
 Утас: Мөнгөтэйгээр өөрчлөх нэр: 30287-26-26-00-00000000
 Утас: ХТД: 6862579
 Банкны нэр: ХААН Банк Утас: 6862579
 Банкны дансны дугаар: 5064284031

Д/А	Барил, нэр, үйлчилгээний нэр	Кол	Хэсгээр	Төл, хэмжээ	Нөгөөд үнэ	Бүтээгд
1	Цэвэрлэж, бооноо хэвээр нь үлдээх, өөрчлөх, өөрчлөх, өөрчлөх	4412100	кг	18	23,900.00	394,000.00
	Барил, нэр, үйлчилгээний нэр					580,000.00
	Нөгөөд үнэ					54,000.00
	Нөгөөд үнэ					.00
	Нөгөөд үнэ					394,000.00

https://mail-attachment.googleusercontent.com/attachment/?ui=2&ik=3610a6b8&ikid=0.1&emmgid=msg.41799764284020793107158b=186d... 1/1



Мөн байгалиараа, эргэн тойрныхоо газар нутагтай адилхан харагдах байдлаар нөхөн сэргээлтийг хийсэн бөгөөд нөхөн сэргээлт хийж ажиллаж байгаа талаараа Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуучлалын яам, аймгийн холбогдох газрын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалт, сумын хяналт, шалгалтын ажлын хэсгийнхэнд танилцуулан ажиллаад байна.


2.3 Тэрбум мод төслийн хүрээнд

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/58 дугаартай зарлигийн 2 дахь заалт тэрбум мод төслийн хүрээнд нийт 200 ширхэг мод тарьж ургуулах, арчлах ажлыг хийхээр тусгаж өгсөн. Тус ажлын хүрээнд Зүүнбаян-Улаан сумын 2024 оны ерөнхий төлөвлөгөөнд тусгуулж, сумын Засаг даргатай гэрээ байгуулан, газарзүйн 46° 31' 21", 102° 35' 46" солбилцолд 200 ширхэг бургас, шар хуайс, үхрийн нүд тариалах ажлын төсөвт өртөг 3.000.000 /гурван сая/ төгрөгийг төсөвлөн шийдвэрлэж, тариалсан. Төлбөр төлсөн баримтыг хавсаргав.

Хүснэгт 4. Мод тарьж ургуулах

Тарих мод бутны төрөл зүйл	Эхний жил
Бургас, Шар хуайс, Үхрийн нүд,	200 ш
Төсөвт өртөг	3.000.000

Зураг 16. Гэрээ болон төлбөр төлсөн баримт



Зураг 17. Мод тариалж буй байдал



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд сумын байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нартай хамтран мод тарих, техникийн нөхөн сэргээлт хийсэн газарт олон наст ургамал /зүлэг/ тарих зэрэг ажил, арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Энэ нь эхнээсээ үр дүнгээ өгч эхэлсэн.

2.4 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэл

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	2024 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
1	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх ёстой байдаг.	Мөн Зүүнбаян-Улаан сумын ойн хортон шавьж устгалд хандив өргөсөн.	Үйл ажиллагааны зардал	Төсөвт өртөгийн зардлыг хандивласан.
3	Техникийн нөхөн сэргээлт хийсэн	Зүүнбаян-Улаан сумын нутаг дэвсгэрт байрлах Улаан дэл гэх газарт бичил уурхайн үйл ажиллагааны улмаас, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж ашиглаж байгаад хаяад явсан, гар аргаар ашигт малтмал олборлогчдын ухсан гээд нийт 5 га талбай эвдэрсэн байсныг техникийн нөхөн сэргээлт хийж ажилласан.	5000.0	Техникийн нөхөн сэргээлтэд 1 экскаватор, 1 ковш, 1 автомашин ажилласан бөгөөд урсгал зардал багтсан дүнгээр нийт 5.000.000 /таван сая/ төгрөгийн өртөгтэй ажил болсон.
Нийт			5000.0	

Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын 1 дүгээр баг Өртөнт гэх газарт бичил уурхайн үйл ажиллагааны улмаас, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж ашиглаж байгаад хаяад явсан, гар аргаар ашигт малтмал олборлогчдын ухсан гээд нийт 50 орчим га талбай эвдэрсэн байсан. Үүнээс нийгмийн хариуцлагын хүрээнд, хариуцлагатай уул, уурхайн жишээгээр 2.5 га газарт техникийн нөхөн сэргээлт хийж ажилласан байна.

Манай компани 2024 онд Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын 1 дүгээр баг Өртөнт гэх газар мэргэжлийн яамд, Ашигт малтмалын газрын баталсан “Уулын ажлын төлөвлөгөө”, “Техник, эдийн засгийн үнэлгээ” зэрэг холбогдох баримт бичгийн дагуу улсаас баримтлаж буй хариуцлагатай уул, уурхайн бодлогын хүрээнд 3 хэсэг газар техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж ажиллалаа.

Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын 1 дүгээр баг Өртөнт гэх газар жалгын эхэнд урдны ажиллаж байсан уул, уурхайн компаниудын болон гар аргаар алт олборлох үйл ажиллагаа явуулж байсан иргэдийн ухсан нөхөн сэргээлт хийгдээгүй 2.5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж ажилласан байна.

Зураг 18. Улаан дэлийг нөхөн сэргээсэн байдал



Зураг 19. Өртөнтийг нөхөн сэргээхээс өмнөх байдал



Зураг 20. Нөхөн сэргээлт хийсний дараах байдал



Зураг 21. Нөхөн сэргээж буй үйл явц



Цаашид дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын 1 дүгээр баг “Нарийн жалга”-д бичил уурхайн үйл ажиллагааны улмаас, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж ашиглаж байгаад хаяад явсан, гар аргаар ашигт малтмал олборлогчдын ухаж эвдэгдсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэхээр ажиллаж байгааг үүгээр илэрхийлж байна.

Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын 1 дүгээр баг “Нарийн жалга”-ыг 2025 оны дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөнд тусган шийдвэрлүүлж, тус компани нь дүйцүүлэн хамгаалахаар ажлын хүрээнд нөхөн сэргээх ажлыг хэрэгжүүлэх саналтай байна.

2.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Тус ордын талбайд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ шаардлагагүй. Харин түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд ойролцоо байдаг 6 айлыг зуслан болон өвөлжөөнд буулгах зорилгоор 213 литр түлшний тусламж үзүүлсэн. Энэ нь зах зээлийн ханшаар нийт 639.000 /зургаан зуун гуяин есөн мянган/ төгрөг болсон байна.

Хүснэгт 6. Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох талаар

1	Б.Банди	20
2	А.Эрдэнэцогт	10
3	Б.Тогтохбаяр	70
4	Д.Самбуу	60
5	А.Эрдэнэбат /томоо/	10
6	Мандах	43
		130 литр

2.6 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Манай компанийн талбайд болон түүний нөлөөллийн бүсэд өнөөгийн байдлаар ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй байна. Төслийн хамрах хүрээнд палеонтологийн дурсгал илрээгүй байна. Хэрэв цаашид төслийн хэрэгжилтийн явцад төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн палеонтологийн олдвор олох үед холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох Шинжлэн ухааны академи, Палеонтологийн хүрээлэн /70118283/, Түүх угсаатны зүйн хүрээлэн /11-458305/-д нэн даруй мэдэгдэх арга хэмжээ авч ажиллах болно.

2.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	2024 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
1	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянаж ажиллах	Үйд ажиллагааны зардал	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянаж ажилласан
2	Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	1000.0	Гал унтраах хэрэгслүүдийг байрлуулж, Аянга зайлуулагчийн бүрэн бүтэн байдлыг хангаж, галын ослын үед хэрэгжүүлэх заавал зөвлөмж бүхий самбар, тэмдэг тэмдэглэгээг байршуулсан.
3	ШТС-ын ойролцоо хамгаалт татах	Үйл ажиллагааны зардлаар	Уурхайд байрлах ШТС-ын аюулгүй ажиллагааг хангах үүднээс хамгаалалтын шороон хөмсөг хийсэн. Шатахуун буух талбайг аюулгүй үүднээс засвалласан. Мөн галын аюулын талаар самбар байршуулан ажилласан. 25 тоннын саванд галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулан ажилласан.
4	Ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Удирдлага ЗБ-ын төлөвлөгөөнд тусгагдсан	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн гамшгаас хамгаалах тухай хуулиар сургалт орж ажилдчаас шалгалт авч ажилласан байна.
5	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээр бүрэн хангах (өлмийний хамгаалалттай түрийтэй гутал, хамгаалалтын нүдний шил, дуулга, тоосны маск, ажлын бээлий гэх мэт)	Удирдлага ЗБ-ын төлөвлөгөөнд тусгагдсан	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээр бүрэн хангасан. Зардалын баримтыг хавсралтаар орууллаа.
6	Далан, хаягдлын санг үер усны үед хальж урсахаас урьдчилан сэргийлэх, байнга тогтворжуулж эвдрэл үүссэхээс урьдчилан сэргийлэх, хяналт мониторинг хийх.	Үйл ажиллагааны зардлаар	Далан, хаягдлын санг үер усны үед хальж урсахаас урьдчилан сэргийлэх, байнга тогтворжуулж эвдрэл үүссэхээс урьдчилан сэргийлж ажилласан.
Нийт зардал		1000.0	

Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших “Өртөнт”-ийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл шороон ордыг ашиглах төслийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

Зураг 22. Уурхайн гэрэлтүүлэг сайжруулсан байдал



Зураг 23. Галын багажны сараа, галын аюулгүй байдлын дүгнэлтүүд



Галын сараанд хүрз тогтоогчтой эсгийний хайрцаг 1ш, Галын хувин 2 ш, Галын дэгээ 1 ш, Галын хөнжил-эсгий 1.5м*2 м, жоотой сүх тус бүр 1 ш, царил 1ш, хүрз 1 ш, галын цохиур 1ш, ABC-4 кг гал унтраагуур 2 ш, хөрөө, лоомбо, тасдагч тус бүр 1 ш байна.

Зураг 24. Галын аюулгүй байдлын самбар, тэмдэгүүд байршуулсан байдал



“Эм эм бэл майнинг” ХХК нь 2024 онд 3 далан байгуулж, 4-6 метрийн өндөршилтэй болсон. Нийт 1 орчим га талбай эзэлсэн, тэгш өндөрлөг талбай бий. Үүний 0.35-иад га нь элсэн талбай. 0.5 орчим га нь устай нуур. Үлдэгдэл нь шаварлаг талбайтай, хаягдлын сан байгаа. Далан, хаягдлын сангийн өндөр нь одоогийн байдлаар нуранга үүсэх аюулгүй байхгүй тул бэхэлгээ хийх шаардлагагүй байна. Гарч болзошгүй эрсдэл аюулаас сэргийлж, явал удаан хугацаанд ашиглах вэ, яаж тогтвортой, аюулгүй байлгах гэдэг дээр ажиллаж байна.

Далан, хаягдлын сангийн тодорхой байршлыг ойр орчмын мал бүхий иргэдэд мэдээлж, далан, хагчдлын сангийнхаа аюулгүй байдлыг ханган тэмдэг тэмдэглэгээг байршуулан, хүн малын осол эндэгдлээс сэргийлэх арга хэмжээ авч ажилласан.

Зураг 25. Далан, хаягдлын сан байгуулсан байдал





2.8 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

2.8.1 Энгийн хог хаягдал

“Эм Эс бэл майнинг” ХХК нь Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын ЗДТГ-тай “Хог хаягдлын гэрээ” байгуулсан бөгөөд улирлын чанартай ажилладаг тул 5 сарын хугацаатай гэрээ хийж сарын төлбөр болох 90.000 төгрөг, нийт 450.000 төгрөгийг төрийн санд тушаагаад байна. Сум гэрээнд заасны дагуу сар бүр ангилан ялгасан хогийг ачиж, өөрийн хогийн цэгт хүргэн ажиллаж байна.

Хүснэгт 8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл


№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	2024 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
1	Хог тээвэрлэх компанитай байгуулсан гэрээний дагуу хогийг цаг хугацаанд нь тээвэрлүүлж байх	450.0	Зүүнбаян-Улаан сумын ЗДТГ-тай байгуулсан гэрээний хуулбарыг хавсралтад хавсаргав.
	Нийт зардал	450.0	

Зураг 26. Энгийн хог хаягдлыг цуглуулах цэг



Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших “Өртөнт”-ийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл шороон ордыг ашиглах төслийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

Зураг 27. Гэрээ төлбөр төлсөн баримт



2.8.2 Аюултай хог хаягдал

Ашигласан тос, масло нь аюултай хог, хаягдал үүсгэдэг ба аюултай хог, хаягдлын бүртгэл хөтөлж, тусгай саванд хаягжуулж, зориулалтын бэлдсэн талбайд хадгалж байсан.

2024 онд техникийн хаягдал тос дахин боловсруулах үйлдвэр болох Сонгино хайрхан дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Хай Би Ойл” ХХК-ийн менежертэй 99098989 дугаарын утсаар холбогдож, техникийн хаягдал тос, маслыг ангилан саван хурааж, намар буухдаа аюултай хог, хаягдлыг авчирч байж гэрээгээ хийж хамтран ажиллахаар болсон.

Үүний улмаас 2024 онд хуримтлагдсан аюултай хог, хаягдлыг түр хугацаанд хадгалах шаардлага гарсан тул аюултай хог, хаягдлын цэг байгуулан, битонжуулан, аюултай хог, хаягдлыг ангилан ялгаж, түр хадгалж байна.

Зураг 28. Аюултай хог хаягдлын зөвгөөрөлтэй ААН-н мэдээлэл

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГТУУЛАХ ТЭГВЭРГЭХ, ХАДГАЛАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ

Шэлүүс Трейд ХХК /Төс агаар/	Элсэнт ХХК /Малтай дүүрэг/	Алтан Оршиной ХХК /Баянголгой дүүрэг/ 9505 2599, 9508 7549	Элсэнт ХХК /Малтай дүүрэг/	Угдас Хүдэр ХХК /Төс агаар/	Ингэтайтас транспорт энх гэрээтэй ХХК /Сонгоногоргой дүүрэг/
Түмэн элсэнт ХХК /Төс агаар/		Хай Би Ойл ХХК /Сонгоногоргой дүүрэг/ 9505 2599, 9508 7549	Элсэнт Малжин ХХК /Сонгоногоргой дүүрэг/	Хөтөө Эм ХХК /Төс агаар/	
		Монгол ХХК /Орхон агаар/ 9505 4955	Элсэнт ХХК /Малтай дүүрэг/ 9505 2599, 9508 7549	Электронс Малтай ХХК /Малтай дүүрэг/	
		ЮТО ХХК /Сонгоногоргой дүүрэг/ 9505 2599, 9508 7549		Элсэнт ХХК /Малтай дүүрэг/	

Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших “Өртөнт”-ийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл шороон ордыг ашиглах төслийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

Мөн манай компани БОАЖЯ-нд аюултай хог хаягдлын үүсгэчийн дугаар /6 оронтой код/ авахаар бүртгэлийн хуудсыг бөглөж хүргүүлээд байна.

Зураг 29. Бүртгэлийн хуудас бөглөсөн байдал



Манай компани нь 2024 онд 500 литр аюултай хог, хаягдал хуримтлуулаад байна. Үүнийг нэр төрлөөр нь ангилвал:

Хүснэгт 9. Хуримтлуулсан аюултай хог хаягдал

№	Ангилал	Хэмжээ	Нэгж
1	Масло	425	Литр
2	Тап	15	Литр
3	Гидро	50	Литр
Нийт		500	

Аюултай хог, хаягдлыг ангилан ялгаж, хадгалах саванд байршуулсан байдал, мөн аюултай хог, хаягдал савлаж хадгалах үйл ажиллагаа эрхлэгчийн тайлангийн маягыг хавсаргав.

Зураг 30. Аюултай хог хаягдлыг цуглуулсан байдал




Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших “Өртөнт”-ийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл шороон ордыг ашиглах төслийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

Хүснэгт 10. ОХШХ-ийн гүйцэтгэл

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	2024 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
Агаар			
1	Агаарын бохирдлын (TSP,PM10,PM2.5,NO ₂ ,SO ₂ ,CO) шинжилгээ мэргэжлийн байгууллагаар хийлгэх	300.0	Өвөрхангай аймаг дахь УЦУОШ-ны төвийн байгаль орчны шинжилгээний лабораторид 2 удаа шинжилгээ хийлгэж сорилтын дүн авсан.
Хөрс			
1	Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	300.0	Өвөрхангай аймаг дахь УЦУОШ-ны төвийн байгаль орчны шинжилгээний лабораторид 2 удаа шинжилгээ хийлгэж сорилтын дүн авсан.
Ус			
1	Усны чанар: pH, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO ₃), Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрс устөрөгчид (нефть бүтээгдэхүүний бохирдол)	300.0	УЦУОШТ-ийн Байгаль орчны шинжилгээний лабораторит усны шинжилгээг 2 удаагийн давтамжтай дээж өгч тус бүрд 9 үзүүлэлтээр шинжлүүлсэн.
Нийт зардал		900.00	

ОХШХ-ийн хүрээнд төлбөр төлсөн баримт болон итгэмжлэгдсэн лабораторийн хариуг хавсралтад хавсаргав.

Зураг 32. Шинжилгээний дүгнэлтүүд




2.10 Ус ашиглалтын гэрээний хэрэгжилт, гүйцэтгэл

2.10.1 Усны эх үүсвэрийн хамгаалалтын талаар

“Эм эс бэл майнинг” ХХК нь Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2.1 дэх заалт буюу “Онцгой хамгаалалтын бүсэд барилга, байгууламж барих, газар хагалах, тэсэлгээ хийх, газар тариалан эрхлэх, ашигт малтмал хайх, олборлох, зэгс, шагшуурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглоно” гэсэн, Байгаль орчин ногоон хөгжил, аялал зуучлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан А-230/127 дугаартай тушаал “Усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх” журмыг тус тус үндэслэн шав тэмдэг тавих ажлыг 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр “Од сүрвэй” ХХК-аар хийлгүүлэн ажилласан.

[Зураг 33. Ажлын тайланг харуулсан байдал](#)



2.10.2 Усан орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Мэргэжлийн байгууллагатай хамтран хаягдлын болон тунгаах нууруудын далангийн бат бөх байдлыг хангаж, шүүрэлт нэвчилтээс хамгаалж ажиллав. MNS 5924:2008 “Нүхэн жорлон, бохир усны нүх”-ний ерөнхий шаардлага хангасан ажилчдын бие засах газрыг байгуулсан.

Ахуйн бохир ус, шатах тослох материал асгарснаас хөрс бохирдон улмаар газрын доорх ус бохирлох тул асгарсан, нэвчсэн тохиолдолд бохирыг даруй арилгаж, саармагжилтыг цаг алдалгүй хийж байсан. Газрын доорх усны чанар нь MNS 0900:2005

стандартыг хангаж буйг хянах зорилгоор ундны ус, түүний савны усанд микробиологийн болон химийн ерөнхий шинжилгээг тогтмол хийлгэж ажилласан.

Усны нөөц, хомсдлыг бууруулах зорилгоор технологид ашигласан бохир усыг MNS4943:2015 стандартад хүргэн цэвэрлэж, дахин ашиглах цэвэрлэсэн ус, технологийн ерөнхий шаардлага MNS 6734:2018-д нийцсэн усыг технологийн усны хэрэгцээнд болон зам усалгаанд ашиглах боломжийг мэргэжлийн байгууллагаас зөвөлгөө авч мөрдлөг болгон ажилласан.

2.10.3 Ус ашигласны дүгнэлт

Зураг 34. Ус ашигласны дүгнэлт

The image displays a digital report for water usage and analysis. On the left is a form titled 'УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ' (Water Usage Summary) with fields for location, date, and contact information. The middle and right sections contain tables of water analysis results, including parameters like pH, hardness, and turbidity, along with a summary table showing total usage and costs.

2.10.4 Хаягдал усны дүгнэлт

Усны газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 60 дугаартай хаягдал усны дүгнэлт гарсан бөгөөд тус дүгнэлтэд хаягдал усыг 6,000,0 м³ эзэлхүүнтэй хаягдлын санд хүлээн авч механик аргаар тунгаан цэвэрлэж эргүүлэн технологид ашиглахаар заасан. Мөн 2023 оны хаягдал усны хэмжээг ашиглах гэрээ дүгнэсэн актыг үндэслэн унд ахуйд 333.0 м³/жил, технологид нөхөн сэлбэлтээр авч ашигласан 138,240.0 м³/жил, эргэлтийн усан сангаас дахин авч ашигласан 357,240 м³/жил байхаар тооцсон.

Тус дүгнэлтийг үндэслэн Онги-таац голын сав газрын захиргаатай 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр ус бохирдуулсны төлбөрийн гэрээ хийж, 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/06 дугаартай сав газрын даргын тушаал гарч, 03 дугаартай зөвшөөрөл олгосон байна.

Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээг холбогдох хууль, тогтоол, тушаал, журмуудыг үндэслэн тооцоод 4,534,583.36 /дөрвөн сая таван зуун гучин дөрвөн мянга

Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших “Өртөнт”-ийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл шороон ордыг ашиглах төслийн 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

Зураг 36. Хаягдал усны төлбөрийн баримт

UFC

ГОЛОМТ БАНК
Саян гэдэгийг олгох үйлчилгээ

ТӨЛБӨРИЙН БАРИМТ / APPLICATION FOR REMITTANCE

Он сар өдөр 2024-7-14	Дүн / Amount Мөнгөний нэгж / Currency 4,534,583.36 <input checked="" type="checkbox"/> MNT <input type="checkbox"/> USD <input type="checkbox"/> бусад	Үсгээр / In words (ДЕРВЕН СЯ ТАВАН ЗУУН ГУЧИН ДЕРВЕН МЯНГА ТАВАН ЗУУН НАЯН ГУРВАН ТӨГРӨГ ГУЧИН ЗУРГААН МӨНГӨ)	
ХЭНЭЭС / FROM	Дансны нэр / Account name ЭМ ЭС БЭЛ МАЙНИНГ Дансны дугаар / Account No	Төлбөрийн зориулалт / Details of payment 3240500065668; 12200166003; 6862578;	
IBAN:	6 0 0 5 1 2 9 0 9 0		
ХЭНД / TO	Банкны нэр / Bank name ГОЛОМТ БАНК Дансны нэр / Account name МТА ТАТВАР Дансны дугаар / Account No	Гарын үсэг / Signature 1st 2nd	Тамра / Stamp
IBAN:	1 1 6 5 1 1 7 3 7 7		
ЗӨВХӨН БАНКНЫ ХЭРЭГЦЭЭНД / FOR BANK USE ONLY ХҮЯ / TELLER: Хянасан / Verified by: Он / сар / өдөр		ТЭМДЭГЛЭЛ / NOTE: Шилжүүлэх данс Хүлээн авах данс Хүлээн авах дансны нэр Хүлээн авагчийн банк Мөнгөн дүн	

2.11 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт.11 БОМТ-ний хэрэгжилтэд зарцуулсан зардал

№	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	2023 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
1	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	7.395.0	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг зохион байгуулсан.
4. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан төслийн хүчин чадал, техник, технологид өөрчлөлт орсон, ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд уг техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэхийг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

5. Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших MV-000436 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хуулсан дискийг Уул уурхай, судалгааны хэлтэст хүлээлгэн өгөхийг “Цариг шонхор” ХХК-д даалгасугай.

УУЛ УУРХАЙ, СУДАЛГААНЫ ХЭЛТСИЙН
ДАРГА  С.ЭНХБОЛД



5371 826



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2022 оны 06 дугаар сарын 10.

№ 7/22-07-04

Улаанбаатар хот

Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших MV-000436 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хэлэлцсэн тухай

“Цариг шонхор” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Цариг ресурс” ХХК боловсруулсан Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд Монгол улсын зөвлөх инженер Л.Жаргалсайхан зөвлөж, Монгол улсын мэргэшсэн инженер Г.Батзаяа шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Техник-эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Энэхүү техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074 дүгээр тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник-эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.
2. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.
3. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь Төслийн эдийн засгийн гол үзүүлэлтүүд, Ерөнхий мэдээлэл, Ордын геологийн судалгаа, Ил уурхайн үндсэн хэмжээсүүд, үйлдвэрлэлийн нөөц, Олборлолт, Уурхайн угаан баяжуулалтын хэсэг, Хүний нөөц, Дэд бүтэц, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Байгаль орчин, Уурхайн үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө, Төслийн эдийн засаг зэрэг 11 бүлэг, Дүгнэлт, Ашигласан материал бүхий 123 хуудас тайлбар бичиг, 15 хавсралт зургаас бүрдэж байна.
4. Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордын MV-000436 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ХХ-14-02 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан

ҮГА-ны даргын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн н-03 дугаар тушаалаар Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл ордын нөөцийг боломжтой С зэрэглэлээр 95.25 мян.м³ элсний нөөц, 6.99 кг буюу химийн цэврээр 5.86 кг, Өртөнтийн алтны шороон ордын нөөцийг бодитой В зэрэглэлээр 23.68 мян.м³ элсний нөөц, шлихээр 7.1 кг буюу химийн цэврээр 5.95 кг, боломжтой С зэрэглэлээр 3.92 мян.м³ элсний нөөц, 1.07 кг буюу химийн цэврээр 0.89 кг, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлийн 122.8 мян.м³ элсний нөөц, 15.16 кг буюу химийн цэврээр 12.70 кг алтны нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

5. Төслийн тодотголд хаягдалгүй олборлох бөгөөд, бохирдол 11.02% буюу 13.19 мян.м³ байхаар тооцож геологийн бодитой В болон боломжтой С зэрэглэлийн нөөцийг магадласан В' үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн тооцсоноор нийт 132.87 мян.м³ элс байна. Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 129.25 мян.м³ хөрс хуулалт хийхээр тооцжээ. Жилд 73.0 мян.м³ элс олборлох хүчин чадлаар нийт үйлдвэрлэлийн нөөцийг 2 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн байна.

6. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын нөөцийн тогтоц болон байршил, хөрсний зузаан, эдийн засгийн үр ашиг зэргийг харгалзан үзэж ил аргаар авто тээвэртэй, гадаад дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ.

7. Ил уурхайд CAT D8 маркийн бульдозер 1 ширхэг, Hyundai 520 маркийн экскаватор 1 ширхэг, HOWO ZZ3257 маркийн автосамосвал 1 ширхэг, SDLG953 маркийн утгуурт ачигч 1 ширхэг, 80СБ скруббер 1 ширхэг гэсэн үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар төлөвлөжээ.

8. Угаан баяжуулах хэсгийн баяжуулах технологийг захиалагч талаас өгсөн техникийн даалгавар болон ойролцоох ордууд болох Баянголын дэнж, Цагаан булагийн ордын баяжуулалтын үр дүн, "Баянголын дэнж-6" алтны шороон ордын 2011 оны ашиглалтын үйл ажиллагааны тайланд үндэслэн урьдчилсан байдлаар сонгосон байна. Угаан баяжуулах хэсгийн хүчин чадал 73.0 мян.м³/жил байна.

9. Ордын элсийг гравитацийн аргаар баяжуулахаар төлөвлөжээ. Үүний үр дүнд 0.11%-ийн гарцтай, 91.7%-ийн металл авалттай баяжмал гарган авч болохыг тогтоосон байна. Анхдагч элсний дундаж агуулгийг 0.111 гр/м³-ээр тооцоонд авч ашигласан байна.

10. Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордын уурхайг өөрийн эх үүсвэр буюу дизель генератораас ЦЭХ-ээр хангахаар төлөвлөсөн байна. Тус уурхайн унд-ахуй болон технологийн усны хэрэгцээнд ашиглалтын хугацаанд 158.64 мян.м³ ус шаардлагатай бөгөөд үүнээс ажилчдын унд ахуйн хэрэгцээнд 0.19 мян.м³ ус, зам усалгаанд 0.16 мян.м³ ус, биологийн нөхөн сэргээлтэнд 7.02 мян.м³ ус, мод усалгаанд 1.12 мян.м³ ус, угаан баяжуулах хэсэгт нэмэлтээр 150.14 мян.м³ ус ашиглахаар тусгажээ. Угаан баяжуулах хэсэгт ашигласан усны 70 хувийг эргэлтийн усаар ашиглах бөгөөд нэмэлтээр ашиглах цэвэр усыг Өртөнтийн гол болон ил уурхайн шүүрлийн усаар хангахаар тусгасан байна.

11. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 114.82 сая төгрөг зарцуулахаар тооцоолсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах зардалд 16.93 сая төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн зардалд 8.87 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 29.48 сая төгрөг, дүйцүүлэн хамгаалах зардалд 20.0 сая төгрөг, төслийн хаалтын зардалд 34.08 сая төгрөг, хаалтын дараах мониторингийн зардалд 5.47 сая төгрөгийг тус тус зарцуулахаар тусгажээ.

12. Уг төслийг хэрэгжүүлсэнээр 37 хүн ажлын байраар хангагдах ба уурхайн ажилчдын сарын дундаж цалин 1,459.0 мян.төг байхаар байна. ТУС-а 0810

13. Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ашиглах ил уурхайн төсөл хэрэгжүүлэхэд нийт 650.97 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс барилга байгууламжийн хөрөнгө оруулалт 160.0 сая төгрөг, машин тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 366.8 сая төгрөг, тавилга эд хогшилд 6.8 сая төгрөг, дэд бүтцийн хөрөнгө оруулалт 85.0 сая төгрөг, капитал ажлын зардал 32.37 сая төгрөг байхаар тус тус тооцжээ. Элэгдэл хорогдлын шимтгэлийн зардал ашиглалтын хугацаанд 316.17 сая төгрөг байхаар тооцоолсон байна.

14. Уурхайг ашиглах төслийн хугацаанд нийт 1,477.35 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 1,959.0 сая төгрөгийн борлуулалт хийж, 481.65 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар байна. Татвар ногдуулсны дараах байдлаар нийт 433.49 сая төгрөгийн цэвэр ашигтай, 749.66 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын дараах мөнгөн урсгалтай ажиллахаар байна. Улс, орон нутгийн төсөвт 267.29 сая төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ. Уурхайн ашиглалтын хугацаанд нэгж бүтээгдэхүүний бүрэн өөрийн өртөг 130,286 төг/гр байна.

15. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 749.66 сая төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV, @10%) 394.08 сая төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 43%, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 2.8 сар байхаар тооцжээ.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголын захиалагч, боловсруулагч болон төслийн шинжээчид дараах асуудлыг анхааруулж байна.

1. Төсөл захиалагч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/205 тоот тушаалаар баталсан Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын дагуу үйл ажиллагаа явуулахыг анхааруулж байна.
2. Төсөл хэрэгжүүлэгч нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм журмын дагуу ашиглалтын үйл ажиллагааг явуулж, олборлосон алтаа Монгол улсын төв банк Монголбанкинд "Цариг шонхор" ХХК-ийн нэр дээр тушааж байхыг анхааруулж байна.
3. Төсөл захиалагчид Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/181, А/458 тоот тушаалаар батлагдсан Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын дагуу Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж холбогдох байгууллагаар хэлэлцүүлэн, уурхайн хаалт, нөхөн сэргээлт хийхийг үүрэг болгож байна.
4. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол Улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулж байна.
5. Байгаль орчныг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд онцгой анхаарч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг ЭБМЗ-өөс даалгаж байна.
6. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан хангамж, дэд бүтцийн сонголт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шийдлийн талаар төслийн эдийн засгийн үндэслэлийн тодотголыг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн "Цариг ресурс" ХХК, мөн ТЭЗҮ-ийн тодотголын үнэн бодит байдал, чанарт дүгнэлт гаргасан шинжээч Монгол Улсын мэргэшсэн инженер Г.Батзаяа тус тус хариуцна.

Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар тогтов. Үүнд:

1. Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших MV-000436 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хүлээн авах;
2. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байхыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулах;.
3. Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших MV-000436 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх арга хэмжээг авах.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ЭЛБЭГЗАЯА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.ЦОГТБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.МӨНХЗОРИГ

“Цариг шонхор” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт ори хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ил аргаар ашиглах техник-э

Блокийн дугаар	Геологийн нөөц								Уурхайн хүрээгээр хаягдах нөөц			
	Блокийн талбай /мян.м ² /	Хөрсний зузаан /м/	Элсний зузаан/м/	Хөрс эзлэхүүн /мян.м ³ /	Элсний эзлэхүүн /мян.м ³ /	Дундаж агуулга /шлих/ гр/м ³	Металлын нөөц /Шлих/ /кг/	Металлын нөөц /хими цэвэр/ /кг/	Дундаж агуулга /шлих/ гр/м ³	Элсний эзлэхүүн /мян.м ³ /	Металлын нөөц /Шлих/ /кг/	Металлын нөөц /хими цэвэр/ /кг/
В-1	12.54	2.98	0.83	37.41	10.41	0.300	3.13	2.62	0.301	0.15	0.05	0.04
В-2	9.96	3.02	0.78	30.06	7.76	0.311	2.42	2.03	0.311	0.21	0.07	0.06
В-3	7.98	3.09	0.69	24.63	5.51	0.282	1.55	1.3	0.282	0.2	0.06	0.05
С-1	1.82	3	0.8	5.45	1.45	0.280	0.41	0.34	0.281	0.02	0.01	0.01
С-2	3.38	3.07	0.73	10.36	2.47	0.266	0.66	0.55	0.267	0.18	0.05	0.04
Нийт В	30.48			92.1	23.68	0.300	7.1	5.95	0.298	0.57	0.17	0.14
Нийт С	5.19			15.81	3.92	0.272	1.07	0.89	0.268	0.2	0.05	0.04
Нийт (В+С)	35.67			107.91	27.6	0.296	8.17	6.84	0.29	0.77	0.22	0.19
Өртөнт												
С-1	2.07	0.48	3.68	0.99	7.6	0.072	0.55	0.46				
С-2	16.88	0.54	3.66	9.11	61.76	0.073	4.52	3.79	0.073	1.1	0.08	0.07
С-3	7.11	0.6	3.64	4.27	25.88	0.074	1.92	1.61	0.074	1.3	0.1	0.08
Нийт С	26.05			14.37	95.25	0.073	6.99	5.86	0.074	2.39	0.18	0.15
Бүгд В	30.48			92.1	23.68	0.30	7.1	5.95	0.298	0.57	0.17	0.14
Бүгд С	31.25			30.18	99.16	0.081	8.05	6.75	0.089	2.59	0.23	0.19
Бүгд (В+С)	61.72	3.03	0.75	122.28	122.84	0.123	15.16	12.7	0.126	3.16	0.4	0.33

2021 оны 12 дугаар сарын 01 ны өдрийн ХХ-14-02 тоот ЭБМЗ-ийн дүгнэлт, 2022 о орд тул уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын (В') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэв. Ордын нийт магадласан В' үйлдвэрлэлийн нөөц нь

Өртөнт хэсгийн В-1, В-2, В-3, С-2, С-1 блокууд тусгай зөвшөөрлийн хилд урд б зөвшөөрлийн хилд тулсан байгаа нь уурхайн хажуу хананд батлагдсан нөөцөөс зайлшгүй х

Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордод хаягдалгүй аш ул чулуулгаас мөн 0.1 м зузаан үеийг элстэй цуг олборлолтонд хамруулахаар тооцсон. Мөн Иймээс ордыг ашиглалтын үед хаягдалгүй олборлоно.

Үзүүлэлт гаргасан:

“Цариг Ресурс” ХХК-ийн
Уулын инженер: / А.Эрдэнэбулг



Их MV-000436 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дахь Өртөнтийн урд дэнжийн дийн засгийн үндэслэлийн тодотголын үйлдвэрлэлийн нөөцийн нэгдсэн хүснэгт

Ашиглалтын нөөц					Бохирдолт			Үйлдвэрлэлийн нөөц						
Хөрс эзлэхүүн /мян.м ³ /	Элсний эзлэхүүн /мян.м ³ /	Дундаж агуулга /шлих/ гр/м ³	Металлын нөөц /Шлих/ /кг/	Металлын нөөц /хими цэвэр/ /кг/	Бохирдолтын хувь	Бохирдуулагч чулуулаг /мян.м ³ /	Блокний дугаар	Бортоор нэмэгдэх хөрс /мян.м ³ /	Хөрс эзлэхүүн /мян.м ³ /	Элсний эзлэхүүн /мян.м ³ /	Дундаж агуулга /шлих/ гр/м ³	Металлын нөөц /Шлих/ /кг/	Металлын нөөц /хими цэвэр/ /кг/	
Өртөнт														
36.86	10.25	0.301	3.08	2.58	24.38	2.5	В'	3.2	38.82	12.75	0.242	3.08	2.53	
29.24	7.55	0.311	2.35	1.97	26.08	1.97	В'	4.11	32.38	9.52	0.247	2.35	1.97	
23.73	5.31	0.282	1.5	1.25	29.56	1.57	В'	4.76	27.72	6.87	0.218	1.5	1.25	
5.36	1.43	0.281	0.4	0.34	25.51	0.36	В'	0.86	6.05	1.8	0.224	0.4	0.34	
9.62	2.29	0.267	0.61	0.51	28.42	0.65	В'	3.33	12.64	2.94	0.208	0.61	0.51	
89.83	23.11	0.3	6.93	5.81	26.13	6.04	В'	12.07	98.92	29.15	0.238	6.93	5.81	
14.99	3.72	0.272	1.01	0.85	27.3	1.02	В'	4.19	18.68	4.74	0.214	1.01	0.85	
104.81	26.83	0.296	7.94	6.66	26.29	7.05	В'	16.26	117.6	33.89	0.234	7.94	6.66	
Орд үүсмэлийн орд														
0.99	7.6	0.072	0.55	0.46	9.15	0.7	В'	0.04	0.82	8.3	0.066	0.55	0.46	
8.95	60.67	0.073	4.44	3.72	6.23	3.78	В'	0.08	7.38	64.45	0.069	4.44	3.72	
4.05	24.58	0.074	1.82	1.53	6.74	1.66	В'	0.07	3.45	26.24	0.069	1.82	1.53	
13.99	92.85	0.073	6.81	5.71	6.61	6.13	В'	0.19	11.65	98.99	0.069	6.81	5.71	
89.83	23.11	0.3	6.93	5.81	26.13	6.04	В'	12.07	98.92	29.15	0.238	6.93	5.81	
28.98	96.57	0.081	7.82	6.56	7.4	7.15	В'	4.38	30.33	103.72	0.075	7.82	6.56	
118.81	119.69	0.123	14.76	12.37	11.02	13.19	В'	16.45	129.25	132.87	0.111	14.76	12.37	

ны 01-р сарын 06-ний өдрийн Н-03 тоот тушаалаар батлагдсан нөөцийн дүгнэлтэд Орд нь III бүлгийн 2-р бүлгийн 4-р зүйлд заасны дагуу бодитой В болон боломжтой С зэрэглэлийн нөөцийг магадласан 132.87 мян.м³ элс букуу хими цэврээр 12.37 кг алт болж байна. /Шлихээр 14.76 кг/.

болон зүүн талаараа, Өртөнтийн үүсмэл ордын хэсгийн С-3, С-2, блокууд баруун талаараа тусгай хяналт хяналт үүсэх нөхцлийг бүрдүүлж байна.

ашиглалт явуулахын тулд алттай элсний давхаргаас дээш орших хучаас хөрсөнд 0.1 м зузаан үе үлдээх, уурхайн хажуугаас элсийг бохирдуулахаар тооцсон бөгөөд эдгээр үеүд бохирдуулагч чулуулаг болно.

Танилцсан:

АМГТГ-ын ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөн, бүртгэл хариуцсан мэргэжилтэн: / Ц.Золзаяа /

Handwritten signature and date: 2022/07/15

Handwritten signature and date: 2022/07/20



“ЭМ ЭС БЭЛ МАЙНИНГ” ХХК-Д

**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

Засгийн газрын II байр, Нэгдсэн Үндэстний гудамж 5/2,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.met.gov.mn

2023. 01. 24 № 13/450.
танай _____-ны № _____-т

**Ерөнхий үнэлгээний дүгнэлт
хүргүүлэх тухай**

Танай компаниас боловсруулан ирүүлсэн Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй Өртөнт /MV-000436/ тоот тусгай зөвшөөрөл бүхий “Алтны үүсмэл шороон орд” төсөлд “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Засгийн газрын 2013 оны “Журам батлах тухай” 374 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.

Ерөнхий үнэлгээний дүгнэлтээр уг төсөлд батлагдсан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Төсөл хэрэгжүүлэгч нь Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг боловсруулан 2023 оны 2 дугаар улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

Хавсралт... хуудастай

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Г.ЭНХМӨНХ



152370378

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ХУУДАС

Улаанбаатар хот

2023 оны 01-р сарын 17

Төслийн дугаар

Дугаар 2023/Е11

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: “Эм эс бэл майнинг” ХХК, /РД: 6862578, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 4-р хороо, арцатын ам,

Холбоо барих утас, И-мэйл хаяг: 976-86045566

Төслийн нэр: “Алтны үүсмэл шороон орд”

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Өвархангай аймгийн Зүүнбаян-Улаан сум

Орон нутгийн санал: Өвархангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын Засаг Даргын 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 1/160 тоот санал, Е-Монголиа О99-2212-000073 дугаар хүсэлт, 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр ирүүлсэн нэмэлт материалыг тус тус үндэслэв.

Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт			Тийм	Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт			Тийм	
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м)			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг			Тийм	

	нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх				
	Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх			Тийм	
Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Агаарын чанар				
	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх			Тийм	
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх			Тийм	
	Усан орчин				
	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх			Тийм	
	Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх			Тийм	
	Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх			Тийм	
	Хөрсөн бүрхэвч				
	Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх			Тийм	
	Хөрс бохирдуулах эсэх			Тийм	
	Хөрс доройтох, цөлжих эсэх			Тийм	
	Ургамлан нөмрөг				
	Ургамалан нөмрөг, ой мод өртөх эсэх			Тийм	
	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх			Тийм	
	Амьтны аймаг				
Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх			Тийм		
Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх			Тийм		
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Нутгийн оршин суугчид				
	Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх	Тийм			
	Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлтэй, эсэх			Тийм	

Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх			Тийм	
Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх			Тийм	
Түүх, соёлын биет өв				
Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх			Тийм	
Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл				
Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх			Тийм	
Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх			Тийм	

Нэгдсэн дүгнэлт:

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр уг төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлагдсан аргачлалын дагуу хийлгэн, нарийвчилсан үнэлгээний тайланг тус яаманд 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлж, шүүмж хийлгэн, шийдвэр гаргуулах шаардлагатай гэж үзлээ.

Онцгойлон анхаарах зүйлс:



1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Байгаль орчны сайдын 2010 оны 156 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал"-ын дагуу төслийн үйл ажиллагаанаас ургамал, хөрс, ус, амьтан, агаар орчинд учруулах, учирсан хохирлыг байгалийн бүрэлдэл тус бүрээр тогтоож, улмаар тухайн газрыг эвдрэлд оруулснаар хохирлын хэмжээг урьдчилан тооцож нийлбэр үнэлгээ гарган төслийг цаашид хэрэгжүүлэх тохиолдолд байгаль орчны хариуцлагын болон эдийн засгийн үндэслэлийг тодорхойлж дүгнэлт гаргах;
2. "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 10¹ дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд төслийн үйл ажиллагаанд хийх асуудлыг холбогдох зардлын хамт тайланд тусгах, дээрх хуулийн хэрэгжилт хангагдсан эсэхэд дүгнэлт боловсруулах;
3. Төслийн бүрэлдэхүүн хэсгээс ялгарах бохирдлыг хэмжээ, түүний тархалт, нөлөөллийн хүрээг нарийвчлан тодорхойлж, зураглал үйлдэн тайланд хавсаргах;
4. Хөрсний элэгдэл, эвдрэлийн өнөөгийн байдлыг тодорхойлж, төслийн үйл ажиллагаанаас үүдэн бий болж болзошгүй сөрөг нөлөөлөл түүнээс сэргийлэх болон нөлөөллийг багасгах арга хэмжээ түүнд шаардагдах хөрөнгө зардлыг нарийвчлан тооцох;
5. Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдал болон ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, материалаас гарах тусгай ангиллын хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй аргаар цуглуулах, ангилан ялгах, дахин ашиглах, устгах, зайлуулах аргыг нарийвчлан тооцож, төслийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болгон хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр устгах, зайлуулах талаар зөвлөмж боловсруулах, бүлэг болгон тайланд тусгах;
6. Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрсөнд үүсэх бохирдлыг нарийвчлан тооцож, түүнийг арилгах, бууруулах талаар зөвлөмж боловсруулж, байгаль орчны бохирдол багатай техник, технологийн сонголт хийх;
7. Төсөл хэрэгжиж буй газар нутагт амьдарч буй иргэд, сумын удирдлагуудтай хамтран ажиллах, төслийн үйл ажиллагааны цар хүрээ, байгаль орчинд халгүй аргаар нийгэм, эдийн засаг, орон нутгийн хөгжилд үзүүлэх давуу болон сул талыг дэлгэрэнгүй танилцуулж, тэдний саналыг албан ёсоор авах, БОННУ-ний ажлын тайланг төсөл хэрэгжих багийн ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл, шийдвэрийг тайланд хавсаргах;

8. Төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, төслөөс шууд болон шууд бусаар хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг тооцож, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх зөвлөмж боловсруулах;
9. Төсөл хэрэгжиж буй газар нутгийн нөлөөллийн бүсийг тогтоож, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх болон байгаль орчныг хамгаалах талаар авах арга хэмжээг тодорхойлон судалгаа хийж дүгнэлт боловсруулах;
10. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн цаг агаарын өөрчлөлтийг тодорхойлж газрын бүрхэвч, гадаргад нөлөөлөх нөлөөлөл, гадаргын ус болон гүний усанд төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөө үзүүлэх эсэхийг тодорхойлох, түүнийг багасгах арилгах арга зам, шаардагдах хөрөнгө зардлыг тогтоох;
11. Төсөлтэй холбоотой батлагдсан ТЭЗҮ, хориглосон, хязгаарласан бүс нутагт хамаарагдаж байгаа эсэх талаар лавлагаа, мэдээллийг холбогдох газраас авах, суурь судалгаагаар тогтоогдсон нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөгөө гарган тайланд хавсаргах;
12. Төслийн үйл ажиллагааны явцад унд ахуйд ашиглаж буй цэвэр усны хэрэглээний хэмжээг эх үүсвэртэй уялдуулан, түүнээс гарах ахуйн бохир усыг тус тус нарийвчилан тооцож тайланд тусгах;
13. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум модны үндэсний хөдөлгөөний хүрээнд төслийн хүрээнд жишиг ногоон байгууламжтай байхаар төлөвлөн тайланд тусгах;
14. Төслийг холбогдох стандартын шаардлагыг хангуулах талаар дүгнэлт боловсруулж, тайланд хавсаргах;
15. Төсөлд ашиглах түүхий эдийн нийлүүлэлтийн талаар нарийвчлан судалж үнэлгээний тайланд тусгах, холбогдох хууль, тогтоомж болон зөвшөөрөл олгосон тухай баримт бичгийг тайланд хавсаргах;
16. Төслийн үйл ажиллагаа дууссаны дараах нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгааллын зардлыг тооцож мониторинг хийх, /дүйцүүлэн хамгааллын үйл ажиллагаа бодит хэрэгжихүйц байхад анхаарах/, хаалтын ажлын каледарчилсан төлөвлөгөө, зардлын тооцоог тус тус урьдчилан тооцож тайланд тусгах;
17. Төслийн ерөнхий дэвсгэр зургийг гаргаж, ОХШХөтөлбөрийг хэрэгжүүлэх цэгүүдийн байршил, 5 жилд олборлолт хийх төлөвлөлтийг тайланд тусгах;
18. Төслийн ТЭЗҮ болон ашиглах талбайтай уялдуулан экологи, эдийн засгийн хохирлын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар боловсруулж тайланд хавсаргах;
19. Төслийн талбайд Газрын төлөв байдлын чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байхыг тайланд тусгах;

Заавал хэрэгжүүлэх шаардлагатай дээр дурдсан арга хэмжээг цаг хугацаанд нь ханган биелүүлээгүй тохиолдолд ерөнхий үнэлгээний дүгнэлтийг хүчингүй болгож “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн дагуу хариуцлага тооцохыг урьдчилан мэдэгдье.

Бусад зүйлс:

1. Төслийн үйл ажиллагаатай холбогдуулж орон нутгийн засаг захиргааны болон байгаль орчны хяналтын байгууллагаас тавигдах нэмэлт шаардлагыг цаг тухай бүрт нь ханган биелүүлж байх;
2. Байгаль орчныг хамгаалах болон байгалийн нөөц баялгийг зохистой ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийг биелүүлэх талаар байгаль орчин, мэргэжлийн хяналтын байгууллагуудтай байнга хамтран ажиллах;
3. Нарийвчилсан үнэлгээний тайланд шүүмж хийлгэн дүгнэлт, шийдвэр гаргуулах асуудлыг ерөнхий үнэлгээгээр тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх;
4. Ерөнхий үнэлгээнд заасан чиглэл, нөхцөл, болзлоос өөр үйл ажиллагаа явуулах болон төсөлд өөрчлөлт орох, эсхүл өргөтгөх, шинэ тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлэх бүрт Ерөнхий үнэлгээнд хамрагдаж байх;

Ерөнхий үнэлгээ хийсэн:	Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн:
Албан тушаал: Байгаль орчин, аялал жуулчлалын яамны шинжээч	Албан тушаал: "Эм эс бэл майнинг" ХХК-ний захирал
Овог, нэр: Н.Эрдэнэчимэг	Овог, нэр: Б.Цолмонбаатар
Гарын үсэг: 	Гарын үсэг: 
Огноо: 2023.01.17	Огноо: 2021.01.25



-- oOo --

Батлав:

БОАЖЯ-НЫ ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ:

Ц. УРАНЧИМЭГ

Шүүмж хийсэн шинжээч:

БОАЖЯ-НЫ ШИНЖЭЭЧ:

З. АЗЖАРГАЛ



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН
НУТАГТ ОРШИХ “ӨРТӨНТИЙН УРД ДЭНЖЙН ХЭСЭГ”
НЭРТЭЙ АЛТНЫ ҮҮСМЭЛ БОЛОН ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН
ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭЛТ ТОДОТГОЛЫН ТАЙЛАН**

(Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-000436)

Тайлан боловсруулсан:



“ЭКО ЭКСПРЕСС” ХХК-ийн

Гүйцэтгэх Захирал:

/Ж.НОМИН-ЭРДЭНЭ/



Төсөл хэрэгжүүлэгч:

“Эм эс бэл майнинг” ХХК-ийн

Захирал:

/Б. ЦОЛМОНБААТАР/



Улаанбаатар хот

2023 он

Батлав:

БОАЖЯ-НЫ ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ:



Ц. УРАНЧИМЭГ

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН
НУТАГТ ОРШИХ “ӨРТӨНТИЙН УРД ДЭНЖЙН ХЭСЭГ”
НЭРТЭЙ АЛТНЫ ҮҮСМЭЛ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
/2023-2025 ОН/**

Тайлан боловсруулсан:



“ЭКО ЭКСПРЕСС” ХХК-ийн

Гүйцэтгэх Захирал:



/Ж.НОМИН-ЭРДЭНЭ/

Төсөл хэрэгжүүлэгч:

“Эм эс бэл майнинг” ХХК-ийн

Захирал:



/Б. ЦОЛМОНБААТАР/

Улаанбаатар хот
2023 он



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

УСНЫ ГАЗАР

Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.gov.mn

2023.03.02 № 011234

танай 2023.02.28 -ны № 23/04 -Т

“ЭКО ЭКСПРЕСС” ХХК-Д

“Усны тухай” хуулийн 16¹.4.10 дахь заалтыг үндэслэн Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт хэрэгжүүлэх “Эм эс бэл майнинг” ХХК-ийн MV-000436 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Өртөнтийн урд дэнжийн хэсэг” нэртэй алтны үүсмэл шороон орд төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайлан болон холбогдох материалыг судалж үзээд усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1. хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



162330563

УСНЫ АШИГЛАХ БОЛОМЖИТ НӨӨЦИЙН ДҮГНЭЛТ

2023 оны 03 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар-40

Улаанбаатар хот
Утас: 51-265528

1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:

"Эм эс бэл майнинг" ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9022050097, регистрийн дугаар: 6862578, утасны дугаар: 86045566

2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага:

"Эко экспресс" ХХК, утасны дугаар: 77111550, 90200506, цахим шуудан: express.eco9@gmail.com

3. Төслийн нэр, байршил:

"Өртөнтийн урд дэнжийн хэсэг" нэртэй алтны үүсмэл шороон орд төсөл нь Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших бөгөөд Онги голын сав газарт хамрагдана.

4. Тусгай зөвшөөрлийн дугаар, үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт:

MV-000436 дугаартай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй.

5. Төслийн хүчин чадал, ажиллах горим:

Төсөл нь хоёр жилийн хугацаанд 132.88 мян.м³ элс олборлохоор төлөвлөсөн байна. Уурхай нь жилд 62 хоног 1 ээлжээр 12 цагийн горимоор 21 ажилчин ажиллана. Цэврийн нуурын эзэлхүүн нь 7,585 м³.

6. Усны эх үүсвэр, байршил:

Төслийн усны хэрэгцээг уурхайн шүүрлийн усаар болон Өртөнт голоос хангахаар төлөвлөсөн байна. Шүүрлийн усны хэмжээ ашиглалтын эхний жил 1,460.6 м³/хон, хоёр дахь жил 1,521.8 м³/хон, /БОННУ тайлангийн 43-45 дугаар хуудас/, Өртөнт голын дундаж урсац 44.7 л/с буюу 3,862.08 м³/хон,

7. Ашиглах усны хэмжээ:

БОНХАЖСайдын А/301 дугаар тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил, гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-оор тооцоход:

- Унд ахуйд 21 хүн х 80 л/хон = 1.68 м³/хон ус (104.16 м³/жил)
- Технологийн ус хэрэглээнд 72.75 мян.м³ х 4 м³ = 4,693.5 м³/хон ус
эргэлтээр 70% буюу 3,285.48 м³/хон
нөхөн сэлбэлтээр 30% буюу 1,408 м³/хон (87,300 м³/жил)
- Зам, талбайн усалгаанд
2,900 м² х 2 л/хон = 5.8 м³/хон ус (116 м³/жил)-д 20 удаа усална
- Нөхөн сэргээлтэд
87,800 м² х 4 л/хон = 351.2 м³/хон ус (10,536 м³/жил)-д 30 удаа усална
- Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд
500 ш х 40 л/хон = 20 м³/хон ус (400 м³/жил)-д 20 удаа усална

Нийт 1,786.68 м³/хон (98,456.16 м³/жил) ус шаардагдахаар байна.

8. Дүгнэлт:

Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах 1,521.8 м³/хон усыг уурхайд шүүрэн орж ирэх шүүрлийн усаар, 264.88 м³/хон усыг Өртөнт голоос (урсац 0.0447 м³/сек, шаардагдах усны хэмжээ 0.003 м³/сек буюу урсцын 6.8%) авч ашиглахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна.

9. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:

Төслийг хэрэгжүүлэх явцад Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 30 дугаар зүйлийн 30.1, 30.6 дахь хэсэг, унд ахуйн хэрэглээнд ашиглах усыг цэвэршүүлэх төхөөрөмжөөр цэвэршүүлж, зам талбайн усалгаанд шаардагдах усыг хур борооны усыг хуримтлуулж ашиглахыг "Эм эс бэл майнинг" ХХК-д зөвлөж байна.

УСНЫ НӨӨЦИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.ГАНТОГТОХ



УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2024 оны 6 дугаар
сарын 20 -ний өдөр

Дугаар Е-2405-000098

Улаанбаатар хот

Утас: 265528, 265578

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

Оноосон нэр: Эм Эс бэл майнинг

Улсын бүртгэлийн дугаар:

Регистрийн дугаар: 6862578

Захирал: Тогооч

Холбоо барих дугаар: 89298252

Факс :

И-мэйл хаяг :

2. Төслийн нэр байршил

Төслийн нэр: Өртөнтийн алтны үүсмэл болон шороон орд ашиглах

Байршил: Өвөрхангай, Зүүнбаян-Улаан, 1-р баг, Эмгэд

Харьяалагдах сав газар: Онги голын сав газар

Хамаарах салбар: Уул уурхай

3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

Эм Эс бэл майнинг

4. Ажиллах горим, хүчин чадал

Үргэлжлэх хугацаа	Ажиллах горим	Жилд ажиллах хоног	Хоногт ажиллах ажилчидын тоо	Хоногт ажиллах цаг
1	1 ээлжээр	94	18	8

5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
Ашигт малтмал олборлон баяжуулах	105430.0	тонн	2024 оны Уулын ажлын төлөвлөгөө Маягт 3-т 105.43 мян.м3 хүдэр олборлон баяжуулахаар төлөвлөсөн байна. нийт 7 сар буюу 210 хоног ажиллана. Маягт 6.2 болон Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд технологийн усны 70%-ийг эргэлтийн усыг ашиглана. Мөн Технологи болон нөхөн сэргээлт, зам талбайн усалгаанд шаардлагатай усны хэрэгцээг шүүрлийн усаар бүрэн хангана.

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	37.0	хоногт 1 хүн	УАТ-2024 он, Маягт 12-т нийт 37 хүн 2 ээлжээр, 210 хоног ажиллана.
Биологийн нөхөн сэргээлт	17000.0	м2	2024 оны Уулын ажлын төлөвлөгөөний Маягт 10-т Биологийн нөхөн сэргээлтийг 1.7 га талбайд хийхээр төлөвлөсөн байна.
"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ	200.0	ш	2024 оны УАТ-ний Маягт 10-т "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 200 ширхэг мод тарина.
Уурхайд шүүрлээр орж ирэх усны хэмжээ	1521.8	м3	БОННУТ 48-р хуудас, ашиглалтын 2 дахь жилд нийт шүүрч орох усны хэмжээ 1521.8 м3/хон байна. Уурхайд орж ирэх шүүрлийн усыг зам талбайн тоосжилт дарах болон, нөхөн сэргээлтэнд ашиглана.
Зам талбайн тоосжилт дарахад зарцуулах усны хэрэглээ	2900.0	м2	БОННУ 43-р хуудас, Хүснэгт 37-д ашиглалтын 2 дахь жилд услах замын талбайн хэмжээ 2900 м2 байна.

6. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ

Эх үүсвэр	Зориулалт	Усны нөөц (л)	Усны нөөц (м3)	Тайлбар
Гадаргын ус	Унд ахуй	44.7	3862.08	Төслийн усны хэрэгцээг уурхайн шүүрлийн ус болон Өртөнтийн голоос хангана.

7. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан ААНБ :	Эко экспресс ХХК
Холбоо барих :	88111018
Нэмэлт мэдээлэл:	2023 оны БОННУ

8. Усны барилга байгууламжууд

Барилга байгууламж	Хүчин чадал (м3)	Хэмжээ хийц
--------------------	------------------	-------------

9. Дамжуулах байгууламж

Хаанаас (эхлэх цэг)	Хаана хүртэл (төгсгөлийн цэг)	Шугамын голч, мм	Дамжуулах шугамын урт, м
---------------------	-------------------------------	------------------	--------------------------

10. Онцгой нөхцөл

- Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглоно;
- Голын хамгаалалтын бүсэд хөрс хуулалт, олборлолт явуулахыг хориглоно;
- Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа голыг хамгаалах арга хэмжээ авах, хөв цөөрөм байгуулах, татмын ойжуулалт хийх г.м;

- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу усны шугам, хоолой бүрд баталгаажсан онлайн тоолуур суурилуулах;

- Усны барилга байгууламжийн зураг төсөл хийлгэж, Усны газраар дүгнэлт гаргуулах;

11. Усны зарцуулалт

Ажлын нэр	Тоо Хэмжээ	Хэмжих нэгж	Усны хэрэглээ, м3 (Норм)	Гүйцэтгэх давтамж	Хэмжих нэгж	Нийт ашиглах усны хэмжээ, м3	Хөнгөлөх усны хэмжээ м3	Төлбөр тооцох усны хэмжээ м3
Ашигт малтмал олборлон баяжуулах	105430.0	тонн	4.0	1.0	Удаа	421,720.00	421,720.00	0.00
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	37.0	хоногт 1 хүн	0.15	210.0	Хоног	1,165.50	0.00	1,165.50
Биологийн нөхөн сэргээлт	17000.0	м2	0.004	16.0	Удаа	1,088.00	1,088.00	0.00
"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ	200.0	ш	0.045	12.0	Удаа	108.00	108.00	0.00
Уурхайд шүүрлээр орж ирэх усны хэмжээ	1521.8	м3	1.0	210.0	Хоног	319,578.00	0.00	319,578.00
Зам талбайн тоосжилт дарахад зарцуулах усны хэрэглээ	2900.0	м2	0.002	90.0	Удаа	522.00	522.00	0.00
Нийт						744,181.50	423,438.00	320,743.50

12. Урьдчилсан байдлаар тооцсон усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ

Ажлын нэр	Төлбөр тооцох усны хэмжээ, м3	Усны ангилал	Хөнгөлөх хувь хэмжээ, %	1 м3 усны үнэ	Усны нөөц ашигласны төлбөр, ₮	Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮	Төлбөл зохих дүн, ₮
Ашигт малтмал олборлон баяжуулах	0.00	Газрын доорх ус	0.0	2047.50	0.00	0.0	0.00
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	1165.50	Газрын доорх ус	0.0	97.50	113,636.25	0.0	113,636.25
Биологийн нөхөн сэргээлт	0.00	Газрын доорх ус	0.0	65.00	0.00	0.0	0.00
"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ	0.00	Газрын доорх ус	0.0	65.00	0.00	0.0	0.00
Уурхайд шүүрлээр орж ирэх усны хэмжээ	319578.00	Газрын доорх ус	0.0	780.00	249,270,840.00	0.0	249,270,840.00

Ажлын нэр	Төлбөр тооцох усны хэмжээ, м3	Усны ангилал	Хөнгөлөх хувь хэмжээ, %	1 м3 усны үнэ	Усны нөөц ашигласны төлбөр, ₮	Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮	Төлбөл зохих дүн, ₮
Зам талбайн тоосжилт дарахад зарцуулах усны хэрэглээ	0.00			0.00	0.00		0.00
Нийт	320,743.50				249,384,476.25		249,384,476.25

13. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө

- Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Онги-Таац голын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулах;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус татах шугам хоолой бүрд баталгаажуулсан онлайн тоолуур суурилуулж, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх
- Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглодог болохыг анхаарах;
- Хаягдал усны дүгнэлтийг дараа жилийн эхний улиралд багтаан гаргуулах;
- Жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх.
- Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны нөөц ашигласны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах.
- Үйл ажиллагаа нь зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед Сав газрын захиргаа болон холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгаж ирүүлэх;
- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (газрын доорх усны хяналт шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2024 оны 12 дугаар сарын 20-ны дотор Усны газарт office@water.gov.mn цахим хаягаар болон холбогдох газруудад хүргүүлж ажиллах;



Байгууллагын нэр: **Усны газар**
Газар хэлтэс: **Усны газар**
Албан тушаал: **Даргын албыг түр орлон гүйцэтгэгч**
Овог нэр: **Зэнээмядар Батбаяр**
Зурсан огноо: **2024.06.21 16:12:50**

Боловсруулсан:

УС АШИГЛАЛТЫН ХЭЛТЭС Мөнхцэцэг

Боловсруулсан огноо: 2024.06.20



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

УСНЫ ГАЗАР

Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.gov.mn

2024.03.06 № 01/273

танай 2024.01.31-ны № 03/24 -т

“ЭМ ЭС БЭЛ МАЙНИНГ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Б.ТОГООЧ ТАНАА

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг болон танай ирүүлсэн 2024 оны 03/24 тоот хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны хаягдал усны дүгнэлтийг гаргаж, ус бохирдуулсны төлбөрийг тооцон хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг: Онги-Таац голын сав газрын захиргаа, Өвөрхангай аймгийн Татварын хэлтэст.

Хавсралт: 3 хуудастай.

Ирээдүй хойч үедээ усны нөөцөө үлдээхийн төлөө усаа хамгаалъя, хуримтлуулъя, хамтран ажиллая.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



З.БАТБАЯР

162430493

ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ

2024 оны 03 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот
Утас:51-265540

1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:

"Эм Эс Бэл Майнинг" ХХК-ийн захирал Б.Тогооч, холбоо барих утасны дугаар 89298252, 80024080, улсын бүртгэлийн дугаар 1011121569, регистрийн дугаар 6862578.

2. Төслийн нэр, байршил

"Эм Эс Бэл Майнинг" ХХК-ийн "Өртөнт" нэртэй MV-000436 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий алтны шороон ордыг ил аргаар олборлох, баяжуулах төсөл нь Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутаг дэвсгэрт байрладаг бөгөөд Онги голын сав газарт хамаарч байна.

3. Хаягдал ус хаях цэгийн байршил, цэвэрлэгээний арга, түвшин:

"Эм Эс Бэл Майнинг" ХХК нь ажилчдын хотхоны унд ахуйн хаягдал усыг цэвэрлэхгүйгээр хөрсөнд нийлүүлдэг байна. Технологийн хаягдал усыг $6,000.0 \text{ м}^3$ эзлэхүүнтэй хаягдлын санд хүлээн авч механик аргаар тунгаан цэвэрлэж эргүүлэн технологид ашигладаг байна.

4. Хаягдал усны хэмжээ:

Тус компанийн 2023 оны хаягдал усны хэмжээг ус ашиглах гэрээ дүгнэсэн актыг үндэслэн унд ахуйд $333.0 \text{ м}^3/\text{жил}$, технологид нөхөн сэлбэлтээр авч ашигласан $138,240.0 \text{ м}^3/\text{жил}$, эргэлтийн усан сангаас дахин авч ашигласан $357,240.0 \text{ м}^3/\text{жил}$ байхаар тооцов.

5. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, төрөл:


Унд ахуйн хаягдал усны хэмжээ 50 м^3 /хоногоос бага, технологийн хаягдал усанд 2023 оны II, IV улиралд сорьцын шинжилгээ хийлгээгүй тул Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2021 оны А-406/226 тоот хамтарсан тушаалаар баталсан "Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.11 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны А-816/218 тоот хамтарсан тушаалаар баталсан "Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ"-г үндэслэн бохирдуулах бодисын хэмжээг унд ахуйд ажилчдын хотхон $1.5 \text{ кг}/\text{м}^3$, технологид бусад үйлдвэрлэл $0.8 \text{ кг}/\text{м}^3$ -ээр тооцов.

6. Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 316 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ", Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2021 оны А-406/226 тоот хамтарсан тушаалаар баталсан "Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлал", Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/635 тоот тушаалаар баталсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам"-ыг тус тус үндэслэн тооцоход **4,534,583.36** /дөрвөн сая таван зуун гучин дөрвөн мянга таван зуун наян гурван төгрөг гучин зургаан мөнгө/ төгрөг ногдож байна.

7. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ

-Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.13 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу Онги-Таац голын сав газрын захиргаанаас "Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг" авч, "Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ" байгуулах;



-Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар баталсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ын 2.1.4, 3.6.1 дэх заалтын дагуу хаягдал усны шугам дээр тоолуур суурилуулах;

-Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2021 оны А-406/226 тоот хамтарсан тушаалаар баталсан “Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тооцоолох аргачлал”-ын хүснэгт №2-ын 14, 32-д заасан хаягдал усанд тодорхойлох үзүүлэлтүүдийг бүрэн шинжлүүлээгүй тохиолдолд бохирдуулах бодисыг жишиг хэмжээгээр авч тооцно;

